МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 02 сарын 08 өдөр Дугаар 67 Улаанбаатар хот

Үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрчим хүчний хэрэглээний босго хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.8 дахь заалт, 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрчим хүчний жилийн хэрэглээний босго хэмжээг хавсралтаар тогтоосугай.

2.Эрчим хүчний жилийн хэрэглээ нь хавсралтад заасан босго хэмжээнээс давсан хэрэглэгчийг үүрэг хүлээсэн хэрэглэгчээр бүртгэх, түүний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрчим хүчний зохицуулах хороо (Э.Түвшинчулуун)-д үүрэг болгосугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Үүрэг хүлээсэн хэрэглэгчийн босго хэмжээг тогтоох тухай” Засгийн газрын 2019 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн 182 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Л.ОЮУН-ЭРДЭНЭ

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД Б.ЧОЙЖИЛСҮРЭН

ШТА0609 9023010224 5498449

Засгийн газрын ....2023.... оны ....02.... дугаар
сарын ....08.... -ны өдрийн ....67.... дугаар
тогтоолын хавсралт

ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЖИЛИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ БОСГО ХЭМЖЭЭ

№	Үүрэг хүлээсэн хэрэглэгчийн ангилал		Босго хэмжээ, нэгж
А. Барилга байгууламж өмчлөгч, эзэмшигч иргэн, хуулийн этгээд			
1.	Төрийн болон орон нутгийн төсөвт байгууллага, хуулийн этгээд (15000 м^3 дээш эзлэхүүн бүхий)*		80 кВт.ц/м^3.жил
2.	Бусад иргэн, хуулийн этгээд		
2.1.	Худалдаа, оффис (30000 м^3 дээш эзлэхүүн бүхий)		80 кВт.ц/м^3.жил, эсхүл 3000 МВт.ц/жил
2.2.	Үйлчилгээ (20000 м^3 дээш эзлэхүүн бүхий)		80 кВт.ц/м^3.жил
Б. Эрчим хүч хэрэглэгч иргэн, хуулийн этгээд (Эрчим хүчний жилийн хэрэглээг хэрэглэгчийн цахилгаан, уур, дулааны нийлбэр хэмжээгээр тооцно.)			
3.	Уул уурхай (олборлолт, боловсруулалт)		4000 МВт.ц/жил
4.	Боловсруулах бусад үйлдвэр		
4.1.	Хүнд үйлдвэр		3000 МВт.ц/жил
4.2.	Дунд/Хүнсний үйлдвэр		2000 МВт.ц/жил
4.3.	Хөнгөн үйлдвэр		2000 МВт.ц/жил
5.	Мэдээлэл, холбоо		3000 МВт.ц/жил
6.	Бусад		2000 МВт.ц/жил
В. Эрчим хүчний үйлдвэрлэл, дамжуулалт, түгээлтийн үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээд			
7.	Эрчим хүч үйлдвэрлэгч (дотоод хэрэгцээний цахилгаан эрчим хүч)		10 хувь/жил, эсхүл 2000 МВт.ц/жил
8.	Эрчим хүч дамжуулагч (дамжуулах сүлжээний алдагдал)		2 хувь/жил
9.	Эрчим хүч түгээгч, хангагч	Цахилгаан түгээх сүлжээний алдагдал	9 хувь/жил**
		Дулааны шугам сүлжээний алдагдал	7 хувь/жил

*Төрийн нууцын тухай хуульд заасан байгууллага, байршил, мэдээлэл бүхий хуулийн этгээд, Барилгын тухай хуулийн 14.6-д заасан хугацаанд ашиглаж буй барилга байгууламж болон төрийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг, орон сууцны хэрэглэгчийг үүрэг хүлээсэн хэрэглэгчээр бүртгэхгүй.

**Цахилгаан түгээх сүлжээний алдагдалд шууд хэрэглэгчийн борлуулалтын утгыг тооцохгүй.

---o0o---